



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 5 сарын 21 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 79,162,619.00 (далан есөн сая нэг зуун жаран хоёр мянга зургаан зуун арван ес) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн захирал Б.Лхагвасүрэн, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
198 дугаар тогтоолын хавсралт



БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын үнэ (төгрөг)
1	Автомашины утаа хэмжигч багаж	2018.07.08	1	25,170,264.00
2	Бензин хөдөлгүүрт утаа хэмжигч багаж	2018.07.08	1	17,258,198.00
3	Дизель хөдөлгүүрт утаа хэмжигч багаж	2018.07.08	1	18,258,000.00
4	Дизель хөдөлгүүрт автомашины утаа хэмжигч багаж	2018.07.08	1	18,476,157.00
	ДҮН	-	4	79,162,619.00 (далан есөн сая нэг зуун жаран хоёр мянга зургаан зуун арван ес)